

INDEPENDENT DIRECTOR REPORT OF XACBANK

By: Erik Versavel
Quarter 4, 2022



STATEMENT

I, Erik Versavel, the Independent Director at the Board of Directors of XacBank, have prepared this Independent Director's Report (the "**Report**") pursuant to: (i) the Company Law and the Banking Law; (ii) banking regulations issued by the Bank of Mongolia ("**BoM**") – Procedures on Good Governance Review of Banks (the "**Good Governance Review**"), and Regulation on Nomination, Appointment, and Resignation of Independent Directors of Banks (the "**INED Regulation**"); (iii) XacBank's Charter and other governance policies applicable.

The Report covers the period of Quarter IV 2022 (the "**Applicable Period**").

1. ATTENDANCE REPORT

(INED Regulation Clauses 5.2.1 and 5.2.2)

The following meetings as shown in Schedule 1 have been convened and held in the Applicable Period.

Board meetings in the Applicable Period

Schedule 1

Meetings	Attendance	Date
Board meeting	As an independent director	1 Dec 2022
Board Audit Committee meeting	As a member	1 Dec 2022
Board Risk Management Committee meeting	As a member	1 Dec 2022
Board Governance, Nomination, Compensation Committee meeting	As an observer	1 Dec 2022
Extraordinary Shareholders' meeting	As an independent director	21 Oct 2022

Board meeting[s]

The board regular meeting was held on [1 Dec 2022] and the relevant agenda items were:

1. Reports of the Board Committees (GNCC, BRMC, BAC)
2. Management Report
3. Budget 2023
4. CEO KPIs
5. IPO and restructuring update
6. IT and Digital Banking update
7. Succession planning

On item 1, 15 recommendations by the GNCC and BRMC collectively were adopted in relation to re-nomination of 7 directors, board budget 2023, board schedule 2023, one-off grant to employees under the long-term incentive program, write-off of assets, revisions to Risk Appetite Statement and simplified procedures for credit exposures to related parties/conflict of interest parties.

On item 3, I asked management to provide their view on the Mongolian economy and where in the cycle we were. As management confirmed my assumption that 'it would get worse before it gets better', and that 'we were at the beginning of a further deterioration especially in respect of purchasing power and family finance', I supported the concept of a conservative budget.

On item 4, I encouraged a discussion on how to focus on a dynamic plan instead of a budget and initiated a discussion on how best to support the management team on reducing attrition and improve engagement amongst (primarily younger) employees.

On item 7, I observed that for most positions there is a serious shortage of 'ready now' and 'ready plus 1', which would imply the need for external recruitment, which is a challenging proposition in the local market. I also cautioned against recruitment of 'rainmakers' as they have a tendency to engage in the wrong business and could have a tendency for lower integrity than what we have now.

Overall, I did not have disagreements with the direction of the discussions and with the specific proposals put forward for decision and voting.

I appreciated the candid update by the CEO of XB in respect of the Banking Sector update with specific focus on the NPL situation, noting that XB's numbers are best in class in this area, thanks to a long-standing prudent risk management approach and prudential guidance by the Board. The liquidity situation in the banking system and pressure on the currency were also discussed at length. Strong performance of XB was discussed and the management commended for these results. My independent view is that this is indeed a remarkable achievement and of critical importance considering the challenges in the local market, and the external pressures on the country. I also welcomed the Chairman's historic context which focused on the strategic decisions of asset growth and who cautioned for diverting from this path at these difficult times.

Furthermore, I have attended the following online voting meetings as shown in Schedule 2.

Online Voting meetings in the Applicable Period

Schedule 2

Meetings	Voting item	Date
Board online voting meeting	Approval of the Compliance Program of XacBank	17-18 Oct 2022
Board online voting meeting	Approval of conflict-of-interest transaction/sale of OREO asset	10-17 November 2022
Board online voting meeting	Approval of conflict-of-interest transaction	9-16 December 2022
Board online voting meeting	Amendment to the approval of the One-Off Incentive Grant	19-26 December 2022
Board Audit Committee online voting meeting	External audit plan – year end 2022	8-28 November 2022
Board Risk Management Committee online voting meeting	none	

On 17 October 2022, XB's CRO requested the Board to approve by online voting a document outlining the Compliance Program of XB, in an urgent request as the approved document had to reach Bank of Mongolia (BoM) by 21 October. I found the document well written and asked clarification questions about the version history, the other compliance documents (like Manual and Handbook) and about the reporting line of Compliance. On that basis I had no issue approving the document.

On 8 November I supported the online proposal for an EY year-end review which covers areas such as responsibilities, independence communication, approach and work plan, general audit procedures, planned time frame, significant audit considerations and others. I saw no reason not to support this valuable external audit.

Also, on 8 November I supported the agenda for the upcoming committee and board meetings on 1 and 2 December 2022.

On 10 November I supported the disposal of a distressed real estate asset, whereby the buyer had provided sufficient proof of available funds. This transaction required board approval because the buyer was an indirectly related party of a shareholder. In view of the detail of the competitive offers and confirmation that no preferential treatment was given, I had no issue giving my approval.

On 8 December I supported the approval of a credit transaction for a corporate client who is considered a related party to XacBank in view of a common shareholder. I saw no reason for a perception of conflict of interest or undue influencing of this credit approval and therefore saw no reason to challenge the recommendation of XacBank risk management committee.

2. CONFLICT OF INTEREST TRANSACTION AND SIGNIFICANT AMOUNT TRANSACTION REPORT

(Banking law Clause 33.5 and INED Regulation Clause 5.2.3)

Pursuant to Clause 33.5 of the Banking Law, independent directors must vote on the conflict-of-interest transactions.

On 10 November I supported the disposal of a distressed real estate asset, whereby the buyer had provided sufficient proof of available funds. This transaction required board approval because the buyer was an indirectly related party of a shareholder. In view of the detail of the competitive offers and confirmation that no preferential treatment was given, I had no issue giving my approval.

On 9 December we were requested to approve an increase of a multiline credit facility for Group, one of the XacBank's important customers which continues to see excellent business growth, healthy profitability, and solvency. The proposal required our approval as the bank and the client share a common shareholder. I approved as I did not see any reason to deviate from the recommendation of the bank's credit committee and saw no indication of undue perception of conflict of interest as related party.

I note that for certain decisions in respect of for example board membership the respective directors abstained from voting.

I note that, in cases where any of the directors had conflict of interest, such director revealed their conflict of interest at the beginning of the meeting and did not vote on the matter.

3. GOVERNANCE REPORT

(Company Law Clause 79.3, INED Regulation Clause 5.2.4, and Good Governance review Clause 3.5)

The above-mentioned clauses of respective laws and regulations provide for independent directors the authority in the oversight over the Board and the executive management if their acts and decisions are in the best interest of the bank and in line with the regulatory requirements for the benefit of the Bank's stakeholders, including but not limit to, shareholders, customers, depositors and employees.

My observation towards the Bank's governance is that there is a clear distinction between the executive management and the board and other stakeholders and that all decisions during the Applicable Period were taken in the best interest of the bank.

Actions taken under the Company Law Clause 79.3 and Good Governance Review Clause 3.5	
Company Law Clause 79.3.1 and Good Governance Review Clause 3.5.5 (BANK'S COMPLIANCE WITH LAWS AND REGULATIONS)	In my observation the bank's management makes all necessary efforts to comply with laws and regulations. In particular, I observed great attention and dedication to complying with the IPO requirements and impact on structure and business.
Company Law Clause 79.3.2 (BANK'S TRANSPARENCY)	Not applicable / not observed.
Company Law Clause 79.3.3 (PROVISION OF INFORMATION TO THE SHAREHOLDERS)	I attended the Extraordinary General Meeting (EGM) - Shareholders' meeting held on 21 October 2022 and made myself available to any questions from the shareholders at the meeting. Apart from shareholders' approval for my appointment as INED, the 2 main topics of the EGM related to the disposal of Tenger Insurance and Tenger Capital. For the disposal of Tenger Insurance relevant questions were asked about the brand, the staff and management and the tax implications.

	<p>For the disposal of Tenger Capital shareholder approval was only required for documentation purposes as management has the mandate to conclude this sale.</p> <p>In respect of the requirements for IPO and the restructuring of the Tenger Financial Group, I observed that some shareholders were reluctant /to inject the minimum required foreign currency investment. I commented that the same shareholders stood to benefit significantly from the disposal of Tenger Insurance and Tenger Capital and that part of the proceeds from these disposals could easily be used to comply with the legal requirements.</p>
<p>Good Governance Review Clause 3.5.1</p> <p>(ENSURING THE DECISIONS MADE BY THE BOARD AND THE MANAGEMENT IS IN THE BEST INTEREST OF THE BANK)</p>	<p>In my observation board and management have at all times endeavoured to act in the best interest of the bank.</p>
<p>Good Governance Review Clause 3.5.2</p> <p>(THE BOARD AND THE MANAGEMENT COMPLIANCE WITH LAWS)</p>	<p>In my observation board and management have at all times endeavoured to act in compliance with applicable laws and regulations.</p>
<p>Good Governance Review Clause 3.5.3</p> <p>(PROTECTION OF COSTUMERS AND DEPOSITORS)</p>	<p>Not applicable / not observed</p>
<p>Good Governance Review Clause 3.5.6</p> <p>(REPORTING OF VIOLATIONS TO BOM)</p>	<p>Not applicable / not observed</p>

4. OTHER

- During the week of the Board Meeting in Ulaanbaatar early December 2022, I had some meetings with businessmen to remain up to date with the situation in the country. We discussed a/o the possible impact of the situation at ETT and the export of coal.
- During the Applicable Period I did not have trainings to support my role as Independent Director. I renewed my membership of the Singapore Institute of Directors.

- On 28 November and 1 December, I had meetings with the CRO of the bank and discussed the overall economic situation in the country and how this is expected to impact the overall performance of the bank and the NPLs.

ERIK VERSAVEL

4 JANUARY 2022



ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН

Эрик Версавел

2022 оны 4 дүгээр улирал



МЭДЭГДЭЛ

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Хараат бус гишүүн Эрик Версавел миний бие: (i) Компанийн тухай хууль (“КтХ”), Банкны тухай хууль (“БтХ”); (ii) Монголбанкны холбогдох журмууд болох “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам” (“Засаглалын хяналт шалгалтын журам”), “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” (“Хараат бус гишүүний журам”); (iii) ХасБанкны Дүрэм болон бусад холбогдох засаглалын бодлого, зарчмын дагуу энэхүү Хараат бус гишүүний тайлан (“Тайлан”)-г бэлтгэсэн болно.

Тайлан нь дараах хугацааг хамарна: [2022 оны 4 дүгээр улирал] (“Тайлант хугацаа”).

1. ОРОЛЦООНЫ ТАЙЛАГНАЛ

(Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.1 болон 5.2.2 дахь заалт)

Тайлант хугацаанд Хүснэгт 1-д заасан дараах хурлуудад оролцож ажиллалаа.

Хамрах хугацаан дахь ТУЗ-ийн хурлууд

Хүснэгт 1

Хурлууд	Оролцсон байдал	Огноо
ТУЗ-ийн ээлжит хурал	Хараат бус гишүүнээр	2022/12/01
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал	Гишүүнээр	2022/12/01
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хурал	Гишүүнээр	2022/12/01
ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны хурал	Ажиглагчаар	2022/12/01
Хувьцаа эзэмшигчдийн хурал	Хараат бус гишүүнээр	2022/10/21

ТУЗ-ийн хурал [хурлууд]

ТУЗ-ийн ээлжит хурал 2022/12/01-ний өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:

1. ТУЗ-ийн дэргэдэх Хороодуудын тайлан (ЗНДЦУХ, ЭУХ болон АХ);
2. Менежментийн тайлан;
3. 2023 оны төсөв;
4. Гүйцэтгэх захирлын 2022 оны KPI
5. IPO болон бүтцийн өөрчлөлт;
6. Мэдээлэл технологи (IT)-ийн шинэчлэл, дижитал банкны явц;
7. Залгамж халааны бодлогын төлөвлөгөө.

Хэлэлцсэн 1 дүгээр асуудлын хүрээнд ТУЗ-ийн дэргэдэх Засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороо (ЗНДЦУХ) болон Эрсдэлийн удирдлагын хороо (ЭУХ)-ны i. ТУЗ-ийн гишүүдийг ТУЗ-д улируулан нэр дэвшүүлэх, ii. 2023 оны ТУЗ-ийн төсөв, iii. 2023 оны ТУЗ-ийн хурлын хуваарь, iv. урт хугацааны урамшууллын хөтөлбөрийн хүрээнд ажилчдад нэг

удаагийн урамшуулах олгох, v. активыг тэнцлээс хасах, vi. банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээ, vii. холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй зээл олгоход баримтлах журмын тухай нийт 15 зөвлөмжийг хэлэлцэж шийдвэр гаргасан.

Хэлэлцсэн 3 дугаар асуудлын хүрээнд Би удирдлагаас Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдал болон түүний мөчлөгийн талаарх тэдний үзэл бодлыг тодруулж асуусан. Нөхцөл байдал сайжрахын өмнө мууддагын адилаар иргэдийн худалдан авах чадвар, өрхийн санхүү улам буурч буй гэсэн миний таамаглалыг удирдлагын зүгээс бататгаснаар Банкны төсвийг батлахад илүү консерватив хандах нь зүйтэй гэж би үзсэн.

Хэлэлцсэн 4 дүгээр асуудлын хүрээнд төсвийн оронд динамик төлөвлөгөө гаргаж ажиллах талаар ТУЗ-ийн хэлэлцүүлгийг чиглүүлж, мөн хүний нөөц, тэр дундаа залуусын идэвх оролцоог сайжруулах талаар удирдлагын багийг хэрхэн дэмжиж ажиллах талаар хэлэлцүүлгийг өрнүүлсэн.

Хэлэлцсэн 7 дугаар асуудлын хүрээнд, албан тушаалууд дээр залган ажиллах бэлтгэгдсэн хүний нөөцийн дутагдлын асуудал хэлэлцэгдсэн бөгөөд хөдөлмөрийн зах зээлээс мэргэжилтэн хайж олох нь дотоодын зах зээлд тун хүнд байна. Миний хувьд 'рэйнмэйкер' төрлийн мэргэжилтэн ажилд авах нь эрсдэлтэй гэдгийг сануулсан. Учир нь ийм төрлийн хүмүүс буруу бизнестэй холбогдох хандлагатай байдгаас Банкны бизнесийн нэр хүндэд муугаар нөлөөлж болзошгүй юм.

Ерөнхийдөө миний хувьд хурлаар хэлэлцсэн асуудал, хурлын шийлдвэр, санал хураалтад зарчмын хувьд зөрүүтэй байр суурь байгаагүй.

ХасБанкны Гүйцэтгэх захирал банкны салбар, тэр дундаа чанаргүй зээлийн нөхцөл байдлын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгсөнд талархаж байна. Мөн ХасБанкны тоон үзүүлэлтүүд зээлийн чанарын хувьд хамгийн сайн байгааг онцолсон бөгөөд энэ нь ТУЗ-өөс урт хугацаанд авч хэрэгжүүлсэн эрсдэлийн удирдлага болон, зохистой удирдлагын үр дүн гэж үзэж байна. Банкны системийн хөрвөх чадвар болон валютын ханшийн дарамтын тухай өргөн хэлэлцсэн. Түүнчлэн, ХасБанкны гүйцэтгэл сайн байгааг дурьдан удирдлагуудыг магтан сайшаав. Миний хараат бус ажиглалтаар энэ нь өндөр үнэлэхүйц ололт амжилт мөн бөгөөд дотоодын зах зээлийн сорилт, улс орны гадаад хүчин зүйлийн нөлөөллийг тооцож үзвэл нэн чухал үр дүн юм. Мөн активын өсөлтийн талаар банкны баримталж буй стратегийн шийдвэрт нөлөөлсөн түүхэн үйл явдлын тоймын талаарх ТУЗ-ийн даргын яриаг миний хувьд талархалтай хүлээн авсан бөгөөд хүнд хэцүү цаг үед тус шийдвэрээс хазайхгүй байхыг бид нарт захиж байсан.

Мөн түүнчлэн Хүснэгт 2-т заасан дараах цахим санал хураалтын хурлуудад оролцсон.

Хамрах хугацаан дахь цахим санал хураалтын хурлууд

Хүснэгт 2

Хурлууд	Санал хураалт	Огноо
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	Банкны хянан нийцүүлэлтийн хөтөлбөр	2022/10/17-10/18
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	Чанаргүй зээлтэй холбоотой хөрөнгө зарж борлуулах сонирхлын зөрчилтэй хэлцэл	2022/11/10-11/17

ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	2022/12/09-12/16
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	Ажилчдын урамшууллыг олгох тухай шийдвэрт нэмэлт өөрчлөлт оруулах	2022/12/19-12/26
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны цахим санал хураалтын хурал	Хөндлөнгийн аудитын 2022 оны аудитын ажлын төлөвлөгөө	2022/11/08-11/28
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны цахим санал хураалтын хурал	байхгүй	

10 дугаар сарын 17-ны өдрийн цахим санал хураалтын хурлаар ХасБанкны Эрсдэл хариуцсан захирлаас Банкны хянан нийцүүлэлтийн хөтөлбөрийг батлах асуудлаар ТУЗ-ийн гишүүдэд цахим санал хураалт явуулах хүсэлт хүргүүлсэн. Тус бичиг баримтыг Монголбанкинд нэн яаралтай хүргүүлэх байсан тул ийнхүү яаралтай шийдвэрлэсэн болно. Тухайн хянан нийцүүлэлтийн хөтөлбөрийн боловсруулалт сайн байсан бөгөөд миний зүгээс өмнө нь хэдэн удаа батлагдаж байсан тухай, бусад хянан нийцүүлэлтийн бичиг баримт болох гарын авлага болон хянан нийцүүлэлтийн мэдээлэх тайлагнах шугамын талаар тодруулсан. Тодруулгын дараа тус бичиг баримтыг батлахыг дэмжсэн.

11 дүгээр сарын 08-ны өдрийн цахим санал хураалтын хурлаар Эрнст Энд Яанг-ийн жилийн эцсийн тайланд хийх аудитын ажлын төлөвлөгөөг хэлэлцэж, дэмжсэн санал өгсөн. Тус төлөвлөгөөнд хариуцлага, хараат бус байдал, арга барил болон ажлын төлөвлөгөө, үндсэн аудитын үйл ажиллагаа, төлөвлөгөөт хугацаа, аудитын чухал ач холбогдолтой асуудлууд багтсан байсан. Тус чухал ач холбогдолтой аудитын төлөвлөгөөг дэмжихгүй байх шалтгаан байгаагүй.

Мөн 11 дүгээр сарын 08-ны цахим санал хураалтын хурлаар, 12 дугаар сарын 01, 02-ны өдөр болох ТУЗ-ийн хурал болон ТУЗ-ийн дэргэдэх Хорооны хэлэлцэх асуудлыг дэмжсэн.

11 дүгээр сарын 10-ны өдрийн цахим санал хураалтын хурлаар өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах асуудлыг дэмжсэн. Учир нь худалдан авагч тал нь хангалттай санхүүгийн эх үүсвэртэй гэдгээ баталж харуулсан. Энэхүү хэлцлийн худалдан авагч тал нь хувьцаа эзэмшигчтэй холбогдох этгээд байсан тул ТУЗ-ийн шийдвэр шаардлагатай байсан. Бусад ирсэн саналуудыг хянаж үзээд мөн холбогдох этгээдэд ямар нэгэн давуу эрх олгоогүйг баталгаажуулсны дараа тухайн асуудлыг би дэмжсэн.

12 дугаар сарын 09-ний өдрийн цахим санал хураалтын хурлаар, Корпорацийн харилцагчийн зээлийн шугамыг батлах асуудлыг дэмжсэн. Учир нь тус харилцагч нь хувьцаа эзэмшигчийн хүрээнд ХасБанкны холбогдох этгээд байсан бөгөөд сонирхлын зөрчил болон зүй бус нөлөөлөл олж хараагүй тул тус асуудлыг дэмжихгүй байх мөн ХасБанкны зээлийн удирдлагын хорооны зөвлөмжийг дэмжихгүй байх шалтгаан олж хараагүй.

2. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БА ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН

(БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг болон Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт)

БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

11 дүгээр сарын 10-ны өдрийн цахим санал хураалтын хурлаар өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах асуудлыг дэмжсэн. Учир нь худалдан авагч тал нь хангалттай санхүүгийн эх үүсвэртэй гэдгээ баталж харуулсан. Энэхүү хэлцлийн худалдан авагч тал нь хувьцаа эзэмшигчтэй холбогдох этгээд байсан тул ТУЗ-ийн шийдвэр шаардлагатай байсан. Бусад ирсэн саналуудыг хянаж үзээд мөн холбогдох этгээдэд ямар нэгэн давуу эрх олгоогүйг баталгаажуулсны дараа тухайн асуудлыг би дэмжсэн.

12 дугаар сарын 09-ний өдрийн хурал, *** Групп-т зээлийн шугам нээж, зээлийн эрхийн хэмжээг нэмэх асуудлыг батлуулах хүсэлтийг ирүүлсэн. Тус Групп нь ХасБанкны чухал үйлчлүүлэгчдийн нэг бөгөөд бизнесийн үйл ажиллагаа нь тогтвортой өсөн дэвжиж, ашигт ажиллагаа болон төлбөрийн чадварийн хувьд хангалттай сайн үзүүлэлттэй байсан. Банкны шууд бус хувьцаа эзэмшигч тус группын хувьцааг мөн эзэмшдэг болохоор холбогдох этгээдийн хүрээнд зүй бусаар нөлөөлж, сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж илтгэх зүйлгүй, мөн банкны зээлийн хорооноос гаргасан зөвлөмжийг дэмжихгүй байх шалтгаан байгаагүй учраас тус асуудалд дэмжсэн санал өгсөн.

ТУЗ-ийн гишүүнчлэлтэй холбоотой шийдвэрийн хувьд ТУЗ-ийн гишүүд тус тусын санал өгөхөөс түдгэлзсэн.

ТУЗ-ийн гишүүдээс сонирхлын зөрчилтэй гишүүн байсан тохиолдолд тухайн гишүүн нь хурлын эхэнд ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж, хэлэлцсэн асуудалд санал өгөөгүй болохыг тэмдэглэж байна.

3. ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

(КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.4 дахь заалт болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг)

Дээр дурдсан хууль тогтоомжоор Хараат бус гишүүн нь Банкны оролцогч талууд, түүний дотор Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон банкны ажилтны эрх ашгийг хамгаалах үүднээс ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь Банкны эрх ашиг, сонирхолд нийцсэн эсэх, мөн үйл ажиллагаа нь хууль тогтоомж дүрэм журамд нийцсэн эсэхэд хяналт тавих эрхтэй.

Миний ажиглалтаар банкны засаглалыг дүгнэхэд, Банкны Гүйцэтгэх удирдлага, ТУЗ болон бусад оролцогч талуудыг хооронд эрх ашгийн хувьд холилдсон зүйл байгаагүй бөгөөд хамрах хугацаанд гаргасан бүх шийдвэрүүд нь банкны эрх ашиг, сонирхолд нийцсэн байсан.

КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэгт заасан арга хэмжээ	
КтХ 79.3.1 болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.5 (БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫН НИЙЦЭЛ)	Миний ажигласнаар банкы удирдлагууд холбогдох хууль, журмыг биелүүлж ажиллахын тулд бүх хүчин чармайлтаа гаргаж ажилласан. IPO-ийн шаардлагыг хангах, бүтэц болон бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөлд маш сайн анхаарлаа хандуулж ажиллаж байсан.
КтХ 79.3.2 (БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ)	Ажиглагдаагүй.
КтХ 79.3.3 (ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГУУЛАХ)	Миний бие 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцсон ба хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултад хариулах, тодруулга хийхэд бэлэн байсан. Миний ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдох асуудлыг батлах болон Тэнгэр даатгал, Тэнгэр капиталыг худалдан борлуулах 2 чухал асуудлыг хэлэлцсэн. Тэнгэр даатгалыг худалдан борлуулах асуудлын хүрээнд брэнд, ажилтнууд болон удирдлага мөн татварын үр дагаварын тухай асуултууд асуусан. Тэнгэр капиталыг худалдан борлуулах асуудлын хүрээнд удирдлага худалдан борлуулахыг эцэслэн шийдвэрлэх бүрэн эрхтэй байсан ч баримтжуулах зорилгоор хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах шаардлагатай байсан. IPO-ийн шаардлага болон Тэнгэр санхүүгийн группын бүтцийн өөрчлөлтийн хүрээнд зарим нэг хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн шаардлагаар хөрөнгө оруулалт хийх талаар таатай хандахгүй байгаа нь анзаарагдсан. Тухайн хувьцаа эзэмшигч Тэнгэр даатгал болон Тэнгэр капиталыг худалдан борлуулахаас олох ашгаас их хэмжээний хувь авахаар байгаа бөгөөд тэр мөнгөний хэсгээс шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийж хуулийн шаардлагыг биелүүлж болно гэдгийг хэлсэн.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.1 (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАРГАСАН ШИЙДВЭР НЬ БАНКНЫ ЭРХ АШИГТ НИЙЦСЭН ЭСЭХ)	Миний ажигласнаар ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага бүх хугацаанд банкны эрх ашгийн төлөө хичээн ажилласан.

Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.2 (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ)	Миний ажигласнаар ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага бүх хугацаанд холбогдох хууль журмын дагуу ажилласан.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.3 (БАНКНЫ ХАРИЛЦАГЧ, ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ)	Ажиглагдаагүй
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.6 (МОНГОЛБАНКИНД ЗӨРЧИЛ МЭДЭЭЛЭХ)	Ажиглагдаагүй

4. БУСАД

- 2022 оны 12 дугаар сарын эхэнд ТУЗ-ийн хурал болох үеэр би бизнес эрхлэгчидтэй хэд хэдэн уулзалт хийж улс орны цаг үеийн байдлын талаар мэдээлэл авсан. Мөн ЭТТ-д үзүүлж болзошгүй нөлөөлөл болон нүүрсний экспортын талаар хэлэлцсэн.
- Хамрах хугацаанд Хараат бус гишүүний үүргээ биелүүлэхэд ямар нэгэн сургалт аваагүй. Сингапур улсад захирлуудын хүрээлэнгийн гишүүнчлэлээ сэргээсэн.
- 11 дүгээр сарын 28 болон 12 дугаар сарын 01-ний өдөр Банкны Эрсдэл хариуцсан захиралтай уулзаж улс орны эдийн засгийн төлөв байдлын талаар ярилцаж, энэ нь цаашдын банкны үйл ажиллагаа, чанаргүй зээлийн нөхцөлд хэрхэн нөлөөлөх талаар хэлэлцсэн.

Эрик Версавел
ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн

2023 оны 01 дүгээр сарын 04